



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/021/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн ахлах аудитор:
Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

| | |
|--|----|
| 1. Хараат бус аудиторын дүгнэлт | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 4 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 8 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 8 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 11 |
| 4. Аудитын тайлан..... | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл | 13 |
| 4.2 Материаллаг байдал | 14 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..... | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. Аудитын илрүүлэлт | 16 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Н.АЛИМАА-Д

2025.01.27 № 32

танай _____ ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тосонцэнгэл сумын Сум дундын ойн ангид Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Завхан аймгийн Тосонцэнгэл суманд ойн тогтвортой менежментийн жишиг тайлбай байгуулахад зориулж 30,836.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, 42,105.2 мянган төгрөгийн ой, хээрийн түймэр унтраах багаж, хамгаалах хувцас хэрэгсэл нийлүүлэгджээ.

Аудитын гол асуудал


Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2024 онд сумын ойн санд шинэс үрийн тайлбай тусгаарлах ажил, үр цэвэрлэх тоног төхөөрөмж худалдан авахаар хийсэн гэрээний дагуу үлдэгдэл 6,120.0 мянган төгрөгийн санхүүжилт нь 12 сарын 31-ээр санхүүжиж зарим тоног төхөөрөмжийг худалдан авах боломжгүй, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 19,691.0 мянган төгрөг, өөрийн орлогоос 6,906.3 мянган төгрөг нийт 26,597.3 мянган төгрөгөөр ойн ангийн

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

2025.01.27



барилгыг сэргээн засварлах ажлыг гэрээний дагуу гүйцэтгүүлж, ажилчдын ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| Данс | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 9,587,612.50 | 16,720,200.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 9,587,612.50 | 16,720,200.00 |
| 351 | Түүхий эд материал | 200,000.00 | 2,957,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 200,000.00 | 525,000.00 |
| 35130 | Эм боох материал | | 2,432,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 9,387,612.50 | 13,763,200.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 202,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,103,200.00 | 8,673,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,296,412.50 | 2,899,000.00 |
| 35450 | Бусад хангамжийн материал | 1,988,000.00 | 1,988,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 311,376,567.55 | 343,438,022.99 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 311,376,567.55 | 343,438,022.99 |
| 392 | Биет хөрөнгө | 156,576,567.55 | 188,638,022.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 21,297,640.00 | 21,297,640.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (13,718,868.60) | (16,462,642.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 67,975,265.00 | 74,824,265.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,963,578.19) | (24,755,030.75) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 43,370,337.75 | 92,326,759.75 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,419,764.94) | (17,345,547.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,720,054.68 | 6,720,054.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - | (2,747,979.24) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 50,520,554.00 | 77,253,934.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (14,205,072.15) | (22,473,431.07) |
| 393 | Биет бус хөрөнгө | 154,800,000.00 | 154,800,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 154,800,000.00 | 154,800,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 320,964,180.05 | 360,158,222.99 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 320,964,180.05 | 360,158,222.99 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 320,964,180.05 | 360,158,222.99 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 158,355,080.00 | 158,355,080.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 158,355,080.00 | 158,355,080.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (162,409,320.33) | (201,603,363.27) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (162,409,320.33) | (162,409,320.33) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 39,194,042.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 199,779.72 | 199,779.72 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 320,964,180.05 | 360,158,222.99 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| Данс | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------|--------------------------------|---------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 9,587,612.50 | 16,720,200.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 9,587,612.50 | 16,720,200.00 |
| 351 | Түүхий эд материал | 200,000.00 | 2,957,000.00 |

| | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 35110 | Тусгай зориулалттай материал | 200,000.00 | 525,000.00 |
| 35130 | Эм боох материал | | 2,432,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 9,387,612.50 | 13,763,200.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0,00 | 202,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,103,200.00 | 8,673,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,296,412.50 | 2,899,000.00 |
| 35450 | Бусад хангамжийн материал | 1,988,000.00 | 1,988,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 311,376,567.55 | 343,438,022.99 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 311,376,567.55 | 343,438,022.99 |
| 392 | Биет хөрөнгө | 156,576,567.55 | 188,638,022.99 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 21,297,640.00 | 21,297,640.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (13,718,868.60) | (16,462,642.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 67,975,265.00 | 74,824,265.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,963,578.19) | (24,755,030.75) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 43,370,337.75 | 92,326,759.75 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,419,764.94) | (17,345,547.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,720,054.68 | 6,720,054.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | - | (2,747,979.24) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 50,520,554.00 | 77,253,934.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (14,205,072.15) | (22,473,431.07) |
| 393 | Биет бус хөрөнгө | 154,800,000.00 | 154,800,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 154,800,000.00 | 154,800,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II | 320,964,180.05 | 360,158,222.99 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 320,964,180.05 | 360,158,222.99 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 320,964,180.05 | 360,158,222.99 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 158,355,080.00 | 158,355,080.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 158,355,080.00 | 158,355,080.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (162,409,320.33) | (201,603,363.27) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (162,409,320.33) | (162,409,320.33) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 39,194,042.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 199,779.72 | 199,779.72 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 320,964,180.05 | 360,158,222.99 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 189,373,481.25 | 319,341,100.00 |
| | Татварын бус орлого | 31,490,000.00 | 48,904,600.00 |
| | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 31,490,000.00 | 48,904,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,890,000.00 | 44,689,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 4,215,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 157,883,481.25 | 270,436,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 147,700,000.00 | 220,036,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 147,700,000.00 | 220,036,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10,540,000.00 | 50,400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,540,000.00 | 50,400,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 188,416,481.25 | 295,613,123.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 188,416,481.25 | 295,613,123.10 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 156,162,481.25 | 295,613,123.10 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 112,558,532.05 | 208,332,136.10 |
| 210101 | Үндсэн цалин | 93,174,301.64 | 133,613,553.89 |
| 210102 | Нэмэгдэл | 12,351,087.52 | 53,259,553.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,815,000.00 | 7,493,028.87 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 2,386,300.00 | 13,966,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,831,842.89 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,015,640.70 | 25,104,607.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 9,669,385.81 | 17,708,231.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,137,574.81 | 1,917,309.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 994,665.90 | 958,654.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 200,647.54 | 837,677.52 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,013,366.64 | 3,682,734.05 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,197,537.29 | 6,632,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 305,549.79 | 309,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,891,987.50 | 6,322,400.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,937,134.00 | 9,301,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,894,800.00 | 1,611,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,976,013.00 | 6,901,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,066,321.00 | 788,580.00 |
| 2105 | Норматив зардал | 396,000.00 | 396,000.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 396,000.00 | 693,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,108,700.00 | 3,133,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 110,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,108,700.00 | 3,023,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,497,200.00 | 4,635,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,497,200.00 | 4,635,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 14,451,737.21 | 38,077,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,787,537.21 | 37,315,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулж зэрэглэл тогтоох | 5,400,000.00 | 648,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 50,000.00 | 50,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 27,200.00 | 27,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 47,000.00 | 36,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,200,000.00 | 7,860,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,084,500.00 | 9,044,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,084,500.00 | 9,044,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32,254,000.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,254,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 32,254,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 356,518.75 | 8,887,976.90 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,767,976.90 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 8,477,090.40 | 6,120,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 957,000.00 | 23,727,976.90 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 957,000.00 | 14,840,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 957,000.00 | 14,840,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 957,000.00 | 14,840,000.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 158,355,080.00 | 1,199,779.72 | (27,991,975.96) | 186,546,835.68 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 158,355,080.00 | 199,779.72 | (27,997,975.96) | 186,546,835.68 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 74,286,496.15 | 74,286,496.15 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 158,355,080.00 | 199,779.72 | (162,409,320.33) | 320,964,180.05 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 158,355,080.00 | 1,199,779.72 | (162,409,320.33) | 320,964,180.05 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 158,355,080.00 | 199,779.73 | (162,409,320.33) | 320,964,180.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 39,194,042.94 | 39,194,042.94 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 158,355,080.00 | 199,779.72 | (201,603,363.28) | 360,158,222.99 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн |
|-----|---|-----------------------|-----------------------|---------------------|
| 102 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 251,479,100.00 | 248,742,523.10 | 2,736,576.90 |
| 103 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 251,479,100.00 | 248,742,523.10 | 2,736,576.90 |
| 104 | Бараа, үйлчилгээний зардал | 251,479,100.00 | 248,742,523.10 | 2,736,576.90 |
| 105 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 209,922,700.00 | 208,332,136.10 | 1,590,563.90 |
| 106 | Үндсэн цалин | 133,842,000.00 | 133,613,553.89 | 228,446.11 |
| 107 | Нэмэгдэл | - | 53,259,553.34 | (53,259,553.34) |
| 108 | Унаа, болон бусад нөхөн олговор | 76,080,700.00 | 7,493,028.87 | 68,587,671.13 |
| 109 | Урамшуулал | - | 13,966,000.00 | (13,966,000.00) |
| 111 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,240,300.00 | 25,104,607.00 | 1,135,693.00 |
| 112 | Тэтгэврийн даатгал | 17,843,400.00 | 17,708,231.38 | 135,168.62 |
| 113 | Тэтгэмжийн даатгал | 2,099,200.00 | 1,917,309.36 | 181,890.64 |
| 114 | ҮОМШӨ ний даатгал | 1,679,400.00 | 958,654.69 | 720,745.31 |
| 115 | Ажилгүйдлийн даатгал | 419,800.00 | 837,677.52 | (417,877.52) |
| 116 | Эрүүл мэндийн даатгал | 4,198,500.00 | 3,682,734.05 | 515,765.95 |
| 117 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,477,400.00 | 6,477,300.00 | 100.00 |
| 118 | Гэрэл цахилгаан | 154,900.00 | 154,900.00 | - |
| 119 | Түлш, халаалт | 6,322,500.00 | 6,322,400.00 | 100.00 |
| 122 | Хангамж, бараа материалын зардал | 4,422,600.00 | 4,422,580.00 | 20.00 |
| 123 | Бичиг хэрэг | 247,800.00 | 247,800.00 | - |
| 124 | Тээвэр (шатахуун) | 3,786,200.00 | 3,786,200.00 | - |
| 125 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 388,600.00 | 388,580.00 | 20.00 |

| | | | | |
|-----|--|-----------------------|-----------------------|-----------|
| 130 | Нормативд зардал | 396,000.00 | 396,000.00 | - |
| 133 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 396,000.00 | 396,000.00 | - |
| 134 | Эд хогшил худалдан авах | 248,700.00 | 248,700.00 | - |
| 138 | Урсгал засвар | 248,700.00 | 248,700.00 | - |
| 139 | Томилолт, зочны зардал | 3,497,200.00 | 3,497,200.00 | - |
| 141 | Дотоод албан томилолт | 3,497,200.00 | 3,497,200.00 | - |
| 143 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 274,200.00 | 264,000.00 | 10,200.00 |
| 145 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 150,000.00 | 150,000.00 | - |
| 146 | Даатгалын үйлчилгээ | 50,000.00 | 50,000.00 | - |
| 147 | Тээврийн хэрэгслийн татвар | 27,200.00 | 27,200.00 | - |
| 148 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 47,000.00 | 36,800.00 | 10,200.00 |
| 197 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 251,510,500.00 | 251,510,500.00 | - |
| 198 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 220,036,500.00 | 220,036,500.00 | - |
| 199 | Улсын төсвөөс санхүүжих | 220,036,500.00 | 220,036,500.00 | - |
| 210 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 31,474,000.00 | 31,474,000.00 | - |
| 211 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,474,000.00 | 31,474,000.00 | - |
| 233 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 7.00 | 7.00 | - |
| 234 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 235 | Гүйцэтгэх ажилтан | 4.00 | 4.00 | - |
| 236 | Үйлчлэх ажилтан | 2.00 | 2.00 | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|-----|--|----------------------|----------------------|
| 102 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 61,710,600.00 | 61,710,600.00 |
| 103 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 61,710,600.00 | 61,710,600.00 |
| 104 | Бараа, үйлчилгээний зардал | 61,710,600.00 | 61,710,600.00 |
| 117 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 155,000.00 | 155,000.00 |
| 118 | Гэрэл цахилгаан | 155,000.00 | 155,000.00 |
| 122 | Хангамж, бараа материалын зардал | 4,879,000.00 | 4,879,000.00 |
| 123 | Бичиг хэрэг | 1,364,000.00 | 1,364,000.00 |
| 124 | Тээвэр (шатахуун) | 3,115,000.00 | 3,115,000.00 |
| 125 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 400,000.00 | 400,000.00 |
| 134 | Эд хогшил худалдан авах | 7,725,000.00 | 7,725,000.00 |
| 135 | Багаж, техник, хэрэгсэл | 4,950,000.00 | 4,950,000.00 |
| 138 | Урсгал засвар | 2,775,000.00 | 2,775,000.00 |
| 139 | Томилолт, зочны зардал | 1,138,000.00 | 1,138,000.00 |
| 141 | Дотоод албан томилолт | 1,138,000.00 | 1,138,000.00 |
| 143 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 47,813,600.00 | 47,813,600.00 |
| 144 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 47,315,600.00 | 47,315,600.00 |
| 145 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 498,000.00 | 498,000.00 |
| 197 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 67,830,600.00 | 67,830,600.00 |
| 210 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 17,430,600.00 | 17,430,600.00 |
| 211 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,215,600.00 | 13,215,600.00 |

| | | | |
|-----|--|---------------|---------------|
| 212 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,215,000.00 | 4,215,000.00 |
| 220 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,400,000.00 | 50,400,000.00 |
| 224 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 50,400,000.00 | 50,400,000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн анги: Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн анги нь Тосонцэнгэл, Идэр Тэлмэн, Их-Уул сумын ойн санг хариуцан, ойг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх, ашиглах, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг төрийн байгууллага юм.

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн зорилго: Хариуцсан сумдын ойн санг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангид мөрддөг хууль:

1. Төрийн албаны тухай хууль
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль
11. Ойн тухай хууль
12. Байгаль орчны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус газар нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал болон мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын

үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн анги нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 39,194.0 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөгөөр/ | | |
|--|--------------------|-------------------|------------------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | | | |
| Бараа материал | 9,587.61 | 16,720.20 | 7,132.58 |
| Үндсэн хөрөнгө | 311,376.56 | 343,438.02 | 320,61.46 |
| Нийт хөрөнгө | 320,964.18 | 360,158.22 | 391,94.04 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 158,355.08 | 158,355.08 | 0.00 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 320,964.18 | 360,158.22 | 391,94.04 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Үнсэн хөрөнгө: Ойн газрын даргын А/453 тушаалаар Ой, хээрийн түймэр унтраах багаж, хамгаалах хувцас хэрэгсэл хуваарилж, үлээгч аппарат 9,087.9 мянган төгрөг, үүргийн шүршигч 9,267.8 мянган төгрөг, цуравдагч 640.9 мянган төгрөг, холбооны хэрэгсэл 582.5 мянган төгрөг, усны сав 1,494.0 мянган төгрөг, галд тэсвэртэй хувцас 18,600.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг орлого авч санхүүгийн тайланд тусган ажилласан.

БОАЖЯ-аас Завхан аймгийн Тосонцэнгэл суманд ойн тогтвортой менежментийн талбай байгуулахад шаардлагатай сургалтын багаж хэрэгсэл хүлээлцэж моторт хөрөө 20375,3 мянган төгрөг, цуулбарын сүх 1188,0 мянган төгрөг, шаантаг 367,4 мянган төгрөг, хөшүүрэг 1294,7 мянган төгрөг, хэмжигч ац 1248,5 мянган төгрөг, цуравдагч 144,1 мянган төгрөг, мөчирлөгөөний хөрөө 1,134.1 мянган төгрөг, метр 763.4 мянган төгрөг, мод хэмжигч 1,745.4 мянган төгрөгийн орлогыг үнэ төлбөргүй орлого авч санхүүгийн тайланд тусган ажилласан.

Өөрийн хөрөнгөөр 4,840.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, 10,000.0 мянган төгрөгийн үр цэвэрлэх тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 223 дугаартай албан тоотоор орлогод авч, санхүүгийн тайланд тусгасан байна. .

Бараа материал: Бараа материалын эхний үлдэгдэл 9,587.6 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 49,073.8 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүйгээр 5,242.5 мянган төгрөгийн бараа шилжүүлэн авч, 47,183.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 16,720.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 158,355.0 мянган төгрөг нь тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 220,036.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 48,904.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 50,400.0 мянган төгрөг, нийт зарлагыг 295,613.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,887.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 310,453.1 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байна. Энэ нь цалин 208,332.1 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| <i>/мянган төгрөгөөр/</i> | | | | | |
|--------------------------------|---|------------------|------------------|----------------|--------------|
| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| Улсын төсвөөс санхүүжих | | | | | |
| | Тосонцэнгэл сум дахь сум дундын ойн анги | | | | |
| 70403 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 319,341.1 | 310,453.1 | | 97.2% |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 319,341.1 | 310,453.1 | 8,887.9 | 97.2% |
| НИЙТ | | 319,341.1 | 310,453.1 | 8,887.9 | 97.2% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 67,830.6 мянган төгрөг зарцуулан ажилласан. Үүнээс: Гэрэл цахилгааны зардалд 155.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 13,64.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 3115.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 400.0 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 4,950.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,775.0 мянган төгрөг, дотоод албан томилолтод 1,138.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 47,813.6 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөгөөр/

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|-----|--|---|-----------------|-----------------|
| 1 | Шууд гэрээ байгуулах /Орон нутгийн хөгжлийн сангаас/ | Байгууллагын гадна, дотно конторын засварын ажилд | 19,600.0 | 26,597.3 |
| 2 | Шууд гэрээ байгуулах /"Залуу ирээдүйн нахиа" ХХК/ | Модны үр цэвэрлэх тоног төхөөрөмж худалдан авах | 10,000.0 | 10,000.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах/СТ БИГ КАПИТАЛ ПРОПЕРТИС ХХК/ | Зөөврийн компьютер | 4,950.0 | 4,950.0 |
| Дүн | | | 34,550.0 | 41,547.3 |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сум дахь Сум дундын ойн анги нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг зөв илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 383,394.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,667.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22,311.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэн тай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн орлогын 383,394.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,667.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22,311.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөвлөмжгүй зөрчилгүй ажилласан.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 43,435.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 37,315.6 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 6,120.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа: Мөнгөн гүйлгээний тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын 37,315.6 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.6-д "бүх зардал", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.1 Төлбөрийн акт тогтоогдоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй



5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ойн санд шинэс үрийн талбай тусгаарлах, үр цэвэрлэх 6,120.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээний хугацаанд нийлүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ойн санд шинэс үрийн талбай тусгаарлах, үр цэвэрлэх тоног төхөөрөмжийг гэрээний дагуу хүлээн авч, ашиглалтад оруулах;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн 6,120.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛГИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | Зөвлөмж | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----------------|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Үүнээс | | Зөвлөмж | |
| | | | | | | | Заглуулсан | Заглуулаагүй | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын 37,315.6 мянган төгрөгийг дутуу тайлагнасан. | 1 | 37,315.6 | | | | | 1 | 37,315.6 | | |
| | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 37,315.6 | | | | | 1 | 37,315.6 | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|-----|---|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Албан тушаалтны тоо | | Тоо | Дүн |
| | | | | | | | | | Тоо | Дүн | | |
| Ойн санд шинэс үрийн талбай тусгаарлах, үр цэвэрлэх 6,120.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээний хугацаанд нийлүүлээгүй байна | 1 | 6,120.0 | | | | | 1 | 6,120.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 6,120.0 | | | | | 1 | 6,120.0 | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-02-20

БОЛОВСРУУЛСАН:

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-ийн

АХЛАХ АУДИТОР

Огноо: 2025-02-20



Ц.ОЮУНСҮВД

Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

Б.ДАГВАСҮРЭН

